



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 1/420

Алтай хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Жинст багийн Хөгжил хорооллын хэрэглэгчдийг дулаанаар хангах эх үүсвэр болон шугам сүлжээний угсралтын ажлын төсвийн тооцоог гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Алтанзагас - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд: Ж.Бат-Эрдэнэ - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
- Б.Бямбадорж - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
- Б.Лхагва-Очир - (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
- М.Туул - (Алтай хотын Захирагчийн албаны ахлах мэргэжилтэн)
- Ц.Мөнхбат - (Алтай хотын Захирагчийн албаны мэргэжилтэн)
- С.Наранбаяр - ("Мандал голомт" ХХК-ийн инженер)
- Д.Батбилэг - ("Ундрам Оюу" ХХК-ийн механик инженер)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2. Дулааны эх үүсвэр, шугам сүлжээний угсралтын ажлын төсвийн тооцоог 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр танилцуулахыг ажлын хэсэг (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г ЧИНБАТ